

## ГАРЧИГ

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	3
2.2. Төслийн товч тодорхойлолт, хүчин чадал:.....	6
3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	8
3.1. Нөлөөллийн хэлбэр үргэлжлэх хугацаа.....	8
4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	10
5. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	12
6. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	13
7. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	14
8. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	15
9. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	16
10. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	17
11. ДҮГНЭЛТ .....	18

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Нэгж талбарын 4118021642 дугаартай 3 га газрын булангийн цэгүүд .....	3
Хүснэгт 2. Төслийн талбайн ашиглалт, физик, хими болон биологийн эвдрэл.....	6
Хүснэгт 3. Болзошигүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим ба эх үүсвэр .....	8
Хүснэгт 4. Төслийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, арилгах, бууруулах арга хэмжээ .....	10
Хүснэгт 5. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө .....	12
Хүснэгт 6. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө .....	13
Хүснэгт 7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө .....	14
Хүснэгт 8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр .....	15
Хүснэгт 9. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	16
Хүснэгт 10. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө.....	17

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн талбайн ерөнхий байршлын зураг.....	4
Зураг 2. Төслийн талбайн районы агаар, сансрын зураг .....	5
Зураг 3. “Молцог элс” аялал жуулчлалын баазын талбайн .....	6
Зураг 4. Төслийн талбайн барилга байгууламжийн зураг .....	7
Зураг 5. Амралтын байрыг үйлчилгээний байруудыг холбосон явган зам .....	19
Зураг 6. Гэрэлтүүлэг, гадна сандал, хогийн сав тохижилт .....	19
Зураг 7. Төслийн талбайн гадна тохижуулалт.....	19
Зураг 8. Нарны зайн хураагуур бүхий гадны талбайн гэрэлтүүлэг, нийтийн эзэмшлийн талбайн хогийн сав.....	20
Зураг 9. Сантехникийн тоног төхөөрөмж.....	21
Зураг 10. Шинээр тарьсан суулгацууд №1 .....	22
Зураг 11. Хог хаягдлыг ангилан ялган хогийн цэг.....	23

## 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

**Төслийн нэр** : “Молцог ресорт” аялал жуулчлалын баазын төсөл

**Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:**

Төсөл хэрэгжүүлэгчийн нэр

- “Хустайн молцог элс” ХХК
  - Хувийн хэргийн дугаар:9011821660
  - Регистрийн дугаар: 6620574

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг, утас

- Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 7-р хороо, 3 хороолол, 12, 272 тоот,
- Утас: 88111316

Компанийн хэлбэр

- Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Үйл ажиллагааны чиглэл

- Аялал жуулчлал

Байгуулагдсан он

- 2004.02.11

Харьяалал

- Монгол

**Төслийн байршил:**


Төв аймгийн Аргалант суманд Хөшөөт багийн нутаг Молцог элс нэртэй газар Улаанбаатар хотоос 85 километр зайд байрлана.

- Талбайн хэмжээ: 3 га
- Талбайн байр зүйн зургийн нэрэлбэр: L48-8

**Газарзүйн солбицол**


Хүснэгт 1. Нэгж талбарын 4118021642 дугаартай 3 га газрын булангийн цэгүүд

№	Уртраг			Өргөрөг		
	градус	минут	секунд	градус	минут	секунд
1	105	52	22.8	47	50	42.4
2	105	52	27.1	47	50	48.6
3	105	52	33.4	47	50	46.8
4	105	52	28.9	47	50	40.5



Зураг 1. Төслийн талбайн ерөнхий байршлын зураг





Зураг 2. Төслийн талбайн районы агаар, сансрын зураг

## 2.2. Төслийн товч тодорхойлолт, хүчин чадал:

“Хустайн молцог элс” ХХК-ийн “Молцог ресорт” аялал жуулчлалын баазын төслийн талбай нь газрын гэрчилгээний 000689361 дугаартай аялал жуулчлал, амралтын зориулалттай 3 га газарт байрлана.

Хүснэгт 2. Төслийн талбайн ашиглалт, физик, хими болон биологийн эвдрэл

Газар ашиглалтын төрөл		Талбай, /га/	Бохирдлын төрөл		
			Физикийн	Химийн	Биологийн
Нийт эзэмшил газар		3	-	-	-
А.Зөвшөөрөлтэй ашиглаж байгаа талбай		3	-	-	-
1.Үйл ажиллагаанд өртөөгүй		2.92	-	-	-
2.Үйл ажиллагаанд өртсөн		0.08	+	-	-
Үүнээс:	Барилга байгууламж	0.075	+	-	-
	Гэр	0.005	+	-	-

Тус нэгж талбарт төслийн үйл ажиллагааны нөлөөгөөр 2.66 хувь нь эвдрэлд өртсөн байна. Газрын гадаргад хужир мараа, намаг ажиглагдаагүй. Өндөр хүчдэл, гуу жалга, үерийн ам, гал зэрэг газар ашиглалтын аюулгүй байдал зөрчигдөөгүй байна.



Зураг 3. “Молцог элс” аялал жуулчлалын баазын талбайн фото зураг





Зураг 4. Төслийн талбайн барилга байгууламжийн зураг

### 3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

#### 3.1.Нөлөөллийн хэлбэр үргэлжлэх хугацаа

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг тогтоох зорилгоор шинжээчдийн хэсэг газар дээр нь очиж, төслийн талбай болон орчны байдалтай танилцаж, холбогдох судалгааг хийсэн болно.

Төслийн болзошгүй нөлөөллийг тогтоохдоо магадлан жагсаах аргыг ашиглаж, үр дүнг дараах хүснэгтэд үзүүлэв. Энэ арга нь төсөл хэрэгжих үед тухайн нөлөөлөл байгаа эсэх дээр тулгуурладаг ба хэрэв тухайн нөлөөлөл байвал "х"-ээр тэмдэглэдэг. Ингэхдээ тухайн нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим зэргийг тодруулах, мөн уг нөлөөлөл байгаль орчин, экологийн тэнцвэрт байдал, орон нутгийн нийгэм-эдийн засагт хэрхэн нөлөөлөх (шууд, шууд бус, эргэж нөлөөлөх, буцалтгүй нөлөөлөх, давхардах эсэх) байдлыг үзүүлдэг.

Хүснэгт 3. Болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим ба эх үүсвэр

Байгаль орчны үзүүлэлт	Шууд	Шууд бус	Өөрөөр	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд эрэг	Бага зэрэг
<b>1. Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт</b>										
Газрын доорх урсцын өөрчлөлт			х							
Гадаргын урсцын өөрчлөлт			х							
Ургамлын бүтцийн өөрчлөлт	х				х					х
Хөрсний элэгдэл, эвдрэл	х				х					х
Зэрлэг амьтдын орон зайн өөрчлөлт			х							
Уур амьсгалын (бичил) өөрчлөлт			х							
<b>2. Байгалийн нөөц ашиглалт</b>										
Газрын гадаргын нөөц баялаг			х							
Бэлчээрийн байдал			х							
Эрдэс түүхий эдийн нөөц			х							
Эрчим хүчний нөөц			х							
<b>3. Байгаль, орчны өөрчлөлт</b>										
Газрын доорх усны чанар, хэмжээ			х							
Гадаргын усны чанар хэмжээ			х							
Агаарын бохирдол			х							
Хөрсний бохирдол			х							
Төслийн үйл ажиллагаанаас ялгарах бохирдуулагч бодис хүний эрүүл мэндэд нөлөөлөх			х							
Дуу чимээ, шуугианы нөлөө			х							
<b>4. Байгалийн өнгө төрх, түүх, соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор</b>										
Байгалийн үзэсгэлэнт өнгө төрх өөрчлөгдөх			х							



Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх			x							
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх			x							
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх			x							
Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх			x							
<b>5. Нийгэмд үзүүлэх нөлөө</b>										
Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх		x			x				+	
Үйлчилгээний салбарын ү/а-нд нөлөөлөх		x			x					+
Хүн амын орлого өөрчлөгдөж, нэмэгдэх		x			x				+	
Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх			x							
<b>6. Эдийн засагт үзүүлэх нөлөө</b>										
Татварын орлого өөрчлөгдөх	x				x		x			+
Орон нутгийн орлого нэмэгдэх	x				x		x			+
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	x				x		x			+
Ажлын байр нэмэгдэх	x				x		x			+
Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	x				x		x			+
<b>7. Бусад нөлөөлөл</b>										
Бохир ус хөрсөнд нэвчиж, хөрс ба грунтын усыг бохирдуулах			x							
Дүн	7	3	21	0	10	0	5	0	2	8

Тайлбар “х” сөрөг нөлөөлөл, (+) эерэг нөлөөлөл

Төслийн болзошгүй сөрөг болон эерэг нөлөөллийн хэлбэр, хугацаа, эрчмийн үндэслэлийг дараах байдлаар гаргасан болно. Үүнд:

*Шууд нөлөөлөл:*

- Төслийн барилга байгууламжийн нөлөөгөөр биет хэмжээгээр хөрс, ургамлан бүрхэвч үүсмэл хэлбэршлээр солигдож, шууд, урт хугацаанд сөрөг нөлөөлнө;
- Дэд бүтцийн хөгжилд эергээр, урт хугацаагаар нөлөөлнө;
- Орон нутгийн орлого, ажлын байр нэмэгдэх зэрэгт төслийн үйл ажиллагаа явагдах хугацаанд болон цаашид эергээр нөлөөлнө;

*Шууд бус нөлөөлөл:*

- Үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд урт хугацаанд эерэг нөлөөлнө;

*Хүчтэй нөлөөлөл:*

- Болзошгүй нөлөөллийн үнэлгээ хийх явцад төслийн зүгээс хүчтэй нөлөөлөх нөлөө байхгүй байна.

#### 4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, түүнээс урьдчилан сэргийлэх үүднээс дараах арга хэмжээг бид хэрэгжүүлсэн.

Хүснэгт 4. Төслийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, арилгах, бууруулах арга хэмжээ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нэгжийн зардал, мян төг	Нийт зардал, мян.төг
<b>Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ</b>					
1	Агаарын бохирдол үүсэх	Ил задгай хог хаягдал шатаахгүй байх	Хог хаягдлыг хогийн цэгт төвлөрүүлэн орон нутгаас заасан цэгт тээвэрлэн хүргэж ил задгай хог шаагаадаггүй байсан.	Үйл ажиллагааны зардал	
2	Авто тээврийн хэрэгслээс тоосжилт, хорт хий ялгарах	Олон салаа шороон зам үүсгэхгүй байх (явган хүний зам болон авто машины замд тэмдэг тэмдэглэгээ хийх)	Молцог ресорт амралтын газар нь олон салаа зам үүсгэлгүй явган болон авто замын тэмдэг тэмдэглэгээ байршуулсан.	200.0	200.0
<b>Дүн</b>				200.0	
<b>Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ</b>					
3	Усан орчин бохирдох, Усны нөөц хомсдох	Ус бохирдуулсны төлбөр төлөх	Хаягдал бохир усны төлбөрийг тогтмол хугацаанд төлж байсан.	120.0	120.0
4		Борооны ус хуримтлуулан дахин ашиглах зөвлөмж	Борооны ус хуримтлуулах боломжит байршлуудыг харгалзан ус хуримтлуулах сав, шугам, шуудуу тохижуулж зассан бөгөөд хуримтлуулсан усыг ногоон байгууламжийн усалгаанд ашигласан.	Үйл ажиллагааны зардал	
5					
6		Ус хангамжийн эх үүсвэрээс 50 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хориглолтын бүс, 200 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хязгаарлалтын бүсийг тогтоож мөрдөж ажиллах	Ус хангамжийн эх үүсвэрээс 50 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хориглолтын бүс, 200 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хязгаарлалтын бүсийг тогтоож мөрдөн ажилласан.	Үйл ажиллагааны зардал	
7		Ус ашиглагч нь цэгийн эзлэхүүний 70-80 хувь дүүрсэн үед суллаж, цэг болон цэгийн орчинд халдваргүйжүүлэх үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжээр халдваргүйжүүлэлтийг хийлгэнэ.	Хаягдал бохир ус тээвэрлэх эрх бүхий аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах гэрээ байгуулан бохир усны цооногийг тухай бүр соруулан ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хийлгэж ажилласан.	Үйл ажиллагааны зардал	
<b>Дүн</b>					
<b>Хөрс, газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ</b>					
8	Хөрсний бохирдол	Барилга байгууламжийн гадна талбайд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, орчныг цэвэр байлгах	Барилга байгууламжийн гадна талбайд ногоон байгууламжийг нэмэгдүүлж орчныг цэвэр байлгаж ажилласан.	Үйл ажиллагааны зардал	

10		Авто машины зогсоол дээр асгарсан тос, тосолгооны материалыг тухай бүрд нь цэвэрлэж авах	Аялал жуулчлалын баазын авто машины зогсоол дээр асгарсан автомашины тос тосолгооны материалыг цаг алдалгүй тухай бүрд нь цэвэрлэж мөн тухайн тээврийн хэрэгслийг дахин тос тосолгооны хэрэгсэл алдуулахгүй байх арга хэмжээг авч байсан.	Үйл ажиллагааны зардал	
<b>Дүн</b>				-	
<b>Биологийн төрөл зүйлд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ</b>					
11	Ургамал	Аялал, жуулчлалын баазын хашаан доторх сул чөлөөт талбайг тарималжуулж нөхөн сэргээх зөвлөмж	Сувиллын хашаанд нийт 20мкв сул чөлөөтэй талбайг зүлэгжүүлж, 30 ширхэг мод шинээр тарьж ургуулсан.	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөнд зардал тусгагдсан	
12	Амьтан	Хууль бус антай тэмцэх (Амрагч, аялагч болон ажилчдад хулгайн ан хийхтэй холбоотой хууль тогтоомж, дүрэм журмын талаарх танилцуулах ухуулах самбар, тэмдэглэгээ байршуулах)	Амрагч аялагчдад байгаль орчны тухай хууль, Амьтны тухай хууль болон Зөрчлийн тухай хуулийн талаар танилцуулга, тараах материал хийж тараасан.	100.0	100.0
			100.0		
13	Цахилгаан эрчим хүчний хэрэглээ	Цахилгаан эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмжийг сонгож хэрэглэх	Амрагч сувилагчдын байр сууц, ажилчдын байр гэрэлтүүлгийг цахилгаан эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмжийг сонгон хэрэглэж байсан.	Үйл ажиллагааны зардал	
14		Ариун цэврийн газар нь агааржуулагч сэнстэй байна.	Баазын ариун цэврийн өрөөнд агааржуулах сэнс байршуулсан.	Үйл ажиллагааны зардал	
<b>Дүн</b>				-	
<b>Нийт дүн</b>				<b>420.0</b>	



## 5. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

“Газрын тухай хууль”-ийн 56.6-р зүйл: Хот, тосгоны өнгө үзэмж, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах, газрыг хамгаалах, нөхөн сэргээх шаардлагын дагуу газар эзэмшигч нь эзэмшилд авсан газрын 10-аас доошгүй хувийг ногоон байгууламжтай байна.

Хүснэгт 5. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

№	2023 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээн	2023 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний биелэлт	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг
1	2	3	4	5
1	Ногоон байгууламж бий болгох	Аялал жуулчлалын баазын хашаанд сул чөлөөтэй 20мкв талбайг зүлэгжүүлэн улиас, чацаргана, нарс тус бүр 15 ширхэг нийт 45 ширхэг тарьсан.	8000 19600	750,000
3	Хөрс бэлтгэх Нүх бэлтгэх	Аялал жуулчлалын баазын хашаан дах сул чөлөөтэй талбайг зүлэгжүүлж мод тарих ажлын бэлтгэл болох нүх ухах, хөрс бэлтгэх ажлыг сувиллын газрын ажилчид гүйцэтгэсэн.	Дотоод зардал	
<b>Нийт дүн</b>				<b>750,000</b>

## 6. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагааны явцад түүх соёлын өвийг хамгаалах зорилгоор төсөл хэрэгжүүлэгч нь дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

- Соёлын өвийг хамгаалах, хадгалах Монгол улсын хууль эрхзүйн орчныг дагаж мөрдөх;
- Төслийн үйл явцад ямар нэг түүх соёлын дурсгалын шинжтэй зүйл илрүүлсэн тохиолдолд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 38.3-ын дагуу холбогдох байгууллага, албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх, боломжтой бол хамгаалах арга хэмжээ авах үүрэг хүлээн ажиллана;

Хүснэгт 6. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг
	1	2	3	4	5
1	Төслийн үйл ажиллагааны үед Археологийн болон палеонтологийн ховор түүхийн дурсгалт олдворууд гарч ирж болзошгүй.	Хэрэв төслийн үйл ажиллагааны үед Археологийн болон палеонтологийн ховор түүхийн дурсгалт олдворууд гарч ирэхэд төрийн холбогдох байгууллагуудад заавал мэдэгдэх ёстой.	Төслийн үйл ажиллагааны явцад Археологийн болон палеонтологийн ховор түүхийн дурсгалт олдворууд олдоогүй болно.	-	-
<b>Нийт дүн</b>					-

## 7. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Ахуйн хаягдлыг үйлдвэрийн түр хогийн цэгт хуримтлуулж улмаар зориулалтын автомашинаар тээвэрлэн Аргалант сумын ТҮК-тэй гэрээ байгуулан төвлөрсөн хогийн цэгт төслийн үйл ажиллагаанаас гарсан хатуу хог хаягдалыг зайлуулна. Цаашид дахин ашиглах боломжтой хаягдлыг аль болох дахин ашиглах хувь хүн, байгууллагуудад нийлүүлж хог хаягдлын хэмжээг бууруулж ажиллах хэрэгтэй.

Хүснэгт 7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	2023 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ	2023 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний биелэлт	Нэгжийн зардал мян.төг	Нийт зардал, мян.төг
1	2	3	4	5
1	Хог хаягдлыг ангилан ялгах зориулалтын цэгийг тохижуулах	Аялал жуулчлалын баазын хашаанд хог хаягдал ангилан ялгах зориулалтын цэгийг байгуулсан.	Үйл ажиллагааны зардал	
2	Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж, ангилан ялгасан хог хаягдлыг хоёрдогч түүхий эд хүлээн авах цэгт тушаах, хог хаягдлыг дахин ашиглах зэрэгт 3R-ийн зарчмыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх.	Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж, ангилан ялгасан хог хаягдлыг хоёрдогч түүхий эд хүлээн авах цэгт тушаан, хог хаягдлыг дахин ашиглаж мөн хог хаягдлыг ангилан ялгах хогийн савыг байршуулсан.		
3	Хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж хүнсний хаягдлыг усгүйжүүлж органик компост бордоо болгон зүлэг, мод арчилгаанд ашиглах	Эх үүсвэр дээр нь ангилан ялгасан хүнсний хог хаягдлыг усгүйжүүлж органик компост бордоо болгон зүлэг, мод тарих үед ашигласан.		
4	Ахуйн шавж, мэрэгч устгах, халдваргүйжүүлэлтийг “MNS 5161-3:2002, Ахуйн шавж, мэрэгч устгах, халдваргүйжүүлэлд. Гуравдугаар хэсэг. Үйлчилгээ стандартын дагуу мэргэжлийн газраар гүйцэтгүүлэх.	Ахуйн шавж, мэрэгч устгах, халдваргүйжүүлэлтийг “MNS 5161-3:2002, стандартын дагуу мэргэжлийн газраар гүйцэтгүүлсэн.	50.0	200.0
6	Хог хаягдлыг тогтмол хугацаанд зайлуулах, орон нутгийн тусгай зөвшөөрөлтэй байгууллагаар хог устгалын цэгт хүргэх	Аялал жуулчлалын бааз Аргалант сумын ЗД-тай байгуулсан “Хог хаягдал тээвэрлэх” гэрээний дагуу хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, эрх бүхий орон нутгийн иргэнтэй хамтран хог хаягдлыг тээвэрлэдэг байсан.	Үйл ажиллагааны зардал	
8	Аж ахуйн нэгж, байгууллага нь хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай хог тээврийн үйлчилгээний гэрээ байгуулах		Үйл ажиллагааны зардал	
9	Хог хаягдлыг зориулалтын цэгээс нэгдсэн хогийн цэгт тээвэрлэхэд MNS 5344:2003, Ахуйн хог хаягдал тээвэрлэлт ангилал. Ерөнхий шаардлага” стандартыг баримтлах.	Хог хаягдлын нэгдсэн хогийн цэгт хүргэхдээ “Ахуйн хог хаягдал тээвэрлэлт ангилал. Ерөнхий шаардлага”-ыг баримталж байсан.		
10	Нийтийн эзэмшлийн талбай, үйлчилгээний орчинд болон хариуцан хамгаалах талбайн орчинд хогийн сав байршуулах.	Жуулчны баазын амрах байр, үйлчилгээний байр, нийтийн эзэмшлийн талбайд хогийн сав байршуулсан.	50.0	200.0
11	Байр сууц бүрд орчинтойгоо зохицсон материал, өнгө үзэмж бүхий хогийн савтай байх.	Байр бүрд өнгө үзэмж бүхий хогийн савыг байрлуулсан.		
12	Засвар үйлчилгээ хийсэн тохиолдолд хог хаягдлыг тухай бүрд цуглуулан тусад нь хадгалж ил задгай хаяхгүй байх	Барилгын засвар үйлчилгээний үед гарсан хог хаягдлыг цуглуулан төвлөрсөн хогийн цэгт хүргэсэн.		
<b>Нийт дүн</b>				<b>400.0</b>



## 8. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хүснэгт 8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	2023 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ	2023 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ	Нэгжийн зардал, төг	Төсөв, мян. төг
1	2	3	4	5
	Агаарын чанар			
1	CO <sub>2</sub> , NO <sub>2</sub> , SO <sub>2</sub> Тоос нийт (PM10, PM2.5) Дуу шуугиан хэмжээ 2цэгт	Нарт ШУҮН консалтинг ХХК-ны хөрс судлалын итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн /шинжилгээний дүнг хавсаргав	73,000 төг	73.0
	Хөрс			
2	Хөрсний хүнд металлууд (Ni, Cd, Pb, Cu, Zn, Cr) 2цэгт	Нарт ШУҮН консалтинг ХХК-ны хөрс судлалын итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн /шинжилгээний дүнг хавсаргав	25,000 төг	25.0
	Усны чанар			
3	Ерөнхий хими 1цэгт	Нарт ШУҮН консалтинг ХХК-ны хөрс судлалын итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн /шинжилгээний дүнг хавсаргав	135,000 төг	135.0
4	Бактериологи 1цэгт		45,000 төг	45.0
<b>Нийт дүн</b>				<b>278.0</b>

## 9. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 9. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв
1	Төсөл хэрэгжих орон нутгийн удирдлагатай нийгмийн хариуцлагын хүрээнд хамтран ажиллах.	Төсөл хэрэгжих орон нутгийн удирдлагатай нийгмийн хариуцлагын хүрээнд хамтран ажилласан.
2	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөн ажилласаар байна. Байгаль орчны боловсрол олгох сургалтыг нийт ажилчдад тогтмол хийж байна.
3	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг зохих хугацаанд хийж гүйцэтгэх ба биелэлтийг жил бүр дүгнэж, дүнг БОАЖЯ-нд хүргүүлж байх, тухайн жилийн БОМТ-г батлуулж байх	Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөө болон төлөвлөгөөний биелэлтийн цаг хугацаанд нь тайлагнан ажилласан.
<b>Нийт</b>		-

## 10. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 10. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр
	1	2
1	Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй орчин байгалийн нөөцийн удирдлагын газарт хүргүүлж тайлагнах	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлж тайлагнаж байсан.
2	Төв аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газар	Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөний тайланг хуулийн хугацаанд нь хүргүүлэн ажилласан.
	<b>Нийт</b>	




## 11. ДҮГНЭЛТ

Төв аймгийн Аргалант сумын Хөшөөт багийн нутаг Молцог элс нэртэй газарт байрлах “Хустайн Молцог элс” ХХК-ийн “Молцог ресорт” аялал жуулчлалын бааз нь 2023 онд хэрэгжүүлсэн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлангийн үр дүнд бид дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- 2023 онд хэрэгжүүлсэн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралт Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын 1 дүгээр хавсралтад заасан аргачлалын дагуу боловсруулав;

“Хустайн Молцог элс” ХХК нь 2023 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтэд нийт 1 428 420 төгрөг зарцуулсан байна.

Хөрс, газрын гадарга, ургамлын нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд явган хүний замыг явган замын хавтангаар хийж арчилгаа, тохижилтыг хийсэн, чиглэл заасан, хориглосон тэмдэг, тэмдэглэгээ байршуулж бусад сул талбайн ногоон байгууламжийг хамгаалах хаалт хашлага хийсэн.



Зураг 5. Амралтын байрыг үйлчилгээний байруудыг холбосон явган зам



Зураг 6. Гэрэлтүүлэг, явган зам



Зураг 7. Төслийн талбайн гадна тохижуулалт



Эрчим хүчийг хэмнэлттэй ашиглах үүднээс нарны зайн гэрлээр ажилладаг гэрэлтүүлгүүдийг гадна талбайн тохижилтод ашиглаж, байр сууц дотор эрчим хүч хэмнэх лед гэрлүүдийг суурилуулсан.



*Зураг 8. Нарны зайн хураагуур бүхий гадна талбайн гэрэлтүүлэг, нийтийн эзэмшлийн талбайн хогийн сав*



Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд ус хэмнэх сантехникийн тоног төхөөрөмжүүдийг сольж суурилуулсан.



*Зураг 9. Сантехникийн тоног төхөөрөмж*



Орчны тохижилт цэцэрлэгжүүлэлтийн ажлын хүрээнд “Тэр бум мод” үндэсний хөдөлгөөн, бүх нийтээр мод тарих аянтай уялдуулан гадна сул чөлөөтэй талбайг тохижуулсан



Зураг 10. Шинээр тарьсан суулгацууд №1





Зураг 11. Хог хаягдлыг ангилан ялгах хогийн цэг